



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Төлбөр тооцооны шинэ горимд шилжих бэлтгэл
ажлын хүрээнд авах арга хэмжээний тухай

Үнэт цаасны зах зээлийн арилжаа, төлбөр тооцооны горимын шинэчилэл хийгдэж байгааг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:


1. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хяналтын “Миллениум Ай Ти” системийг нэвтрүүлж, шинэ горимд шилжихтэй холбогдуулан Хөрөнгийн бирж дээр хийгдсэн арилжааны төлбөр тооцооны гүйцэтгэлийг баталгаажуулах үүднээс “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн брокер, дилерийн компаниудаас мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх замаар “ҮЦТТХТ” ХХК-ийн дэргэд “Төлбөрийн баталгааны сан” байгуулахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн брокер, дилерийн компаниудаас “Төлбөрийн баталгааны сан”-д татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээг тооцох аргачлалыг хавсралтаар баталсугай.
3. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн брокер, дилерийн компани тус бүрээр хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу мөнгөн хөрөнгийг “Төлбөрийн баталгааны сан”-д зориулан нээсэн тусгай дансанд төвлөрүүлэхийг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.
4. Төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооноос зөвшөөрөл өгөх хүртэл аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй, зөвхөн хуримтлал үүсгэн ажиллахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д даалгасугай.
5. Дараах арга хэмжээг авч ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн нийт брокер, дилерийн компаниудад үүрэг болгосугай:

1/ “Төлбөрийн баталгааны сан”-д мөнгөн хөрөнгийг 2012 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн төвлөрүүлэх;

2/ “Төлбөрийн баталгааны сан”-д татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулах журам батлах хүртэл эрсдэл үүсгэхгүй байх зорилгоор харилцагчдын арилжааны банкин дахь үнэт цаас худалдах, худалдан авах дансанд үнэт цаасны төлбөрийг 100 хувь урьдчилан байршуулж, биржийн арилжаанд оролцож байх;

3/ Харилцагчийн мөнгөн хөрөнгийг төлбөр тооцоо гүйцэтгэх банкинд харилцагч тус бүр өөрийн нэр дээр тусгайлан нээсэн дансанд байршуулсны үндсэн дээр арилжаанд оролцох.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн
112 дугаар тогтоолын хавсралт

МӨНГӨН ХӨРӨНГИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

1. Төлбөрийн баталгааны санд татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээг дараах байдлаар тооцоолно:

1.1. “Төлбөрийн баталгааны сан” байгуулагдахаас өмнөх 3 сарын турш “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны системээр хийгдсэн нийт худалдан авах хэлцлийн нэг өдрийн дундаж дүнг тодорхойлно.

1.2. Төлбөр тооцоо 3 өдрийн дараа гүйцэтгэгдэх тул уг дүнг 3-аар үржүүлэн тооцно.

1.3. Гишүүнд “ҮЦГТТХТ” ХХК-ийн төлбөр тооцооны түр журмын дагуу арилжааны хязгаарын 30 хувьтай тэнцэх хэмжээний барьцаа хөрөнгийг байршуулж байгаа тул дээр гарсан дүнг 30 хувиар бууруулна.

1.4. Төлбөрийн баталгааны санд байршуулах хамгийн бага хэмжээ болох 2 /хоёр/ сая төгрөг нь энэхүү урьдчилсан байдлаар тооцоологдож гарсан сангийн хэмжээг нэмэгдүүлнэ.

2. “Төлбөрийн баталгааны сан”-д гишүүний анх байршуулах хөрөнгийн хэмжээг дараах байдлаар тооцоолно:

2.1. “Төлбөрийн баталгааны сан” байгуулагдахаас өмнөх 3 сарын турш хийсэн арилжааны хувьд нэг өдрийн авсан, зарсан арилжааны нэгтгэсэн дүнг өдөр тус бүрээр тооцсоны нэг өдрийн дундаж дүнг тодорхойлно.

2.2. Төлбөр тооцоо 3 өдрийн дараа гүйцэтгэгдэх тул уг дүнг 3-аар үржүүлэн тооцно.

2.3. Гишүүн тус бүрийн дээрх дүнг нийт гишүүдийн нийлбэр дүнд хуваана.

3. Энэхүү тооцооллын хариу нь тухайн гишүүний Төлбөрийн баталгааны санд байршуулах хөрөнгийн хувь хэмжээ байна.